



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/793

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Тусгай тоноглолтой автомашин нийлүүлэх (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар) нийлүүлэгчээр шалгарсан “Хөтөл нутаг” ХХК-тай 148 500 000 (нэг зуун дөчин найман сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандартын дагуу хүлээлгэн өгөхийг “Хөтөл нутаг” ХХК-ийн захирал (П.Чулуунсүх)-д үүрэг болгосугай.

3. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0328010942

Аймгийн Засаг даргын 2023 оны  
11 дугаар сарын 27-ны өдрийн  
11793 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Дүн	Хариуцах албан тушаалтан
1.	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.	Д.Батцогт
2.	Баталгаат хугацаа	Барааг хүлээлгэн өгсөнөөс хойш 12 сар байна.	Ү.Бямбасүрэн
3.	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.	Д.Батцогт
4.	Нийлүүлэгчийг төлөх алданги	Хоног тутамд 0,2 хүртэл хувь байна.	Д.Батцогт